



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр, Баасан гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	<b>1</b>
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	<b>2-10</b>
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	<b>11-43</b>

<b>1. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/</b>	<b>12-14</b>
<b>2. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /“Газарзүйн нэрийн жагсаалт батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/</b>	<b>14-15</b>
<b>3. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/</b>	<b>15-17</b>
<b>4. Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>	<b>17-19</b>
<b>5. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлт /Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/</b>	<b>19-35</b>
<b>6. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>	<b>36-42</b>
<b>7. Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох</b>	<b>42-43</b>

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
4 дүгээр сарын 17-ны өдөр /Баасан гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 71 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.<sup>1</sup>

Томилолттой: Д.Амарбаясгалан, Х.Баттулга, Д.Ганмаа, Г.Дамдинням, Т.Доржханд, Х.Жангабыл, Ж.Золжаргал, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, О.Номинчимэг, Л.Соронзонболд, Д.Үүрийнтуяа;

Чөлөөтэй: О.Алтангэрэл, С.Амарсайхан, Ч.Анар, Ц.Мөнхбат, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан, Х.Болормаа, Б.Жавхлан, Ч.Лодойсамбуу, Л.Мөнхбаатар, Б.Тулга, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: О.Амгаланбаатар, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, Г.Уянгахишиг;

Хоцорсон: Э.Болормаа-1 цаг 03 минут, Х.Булгантуяа-18 минут, Д.Ганбат-1 цаг 57 минут, Б.Жаргалан-01 минут, Д.Жаргалсайхан-03 минут, П.Мөнхтулга-46 минут, Ц.Мөнхтуяа-23 минут, З.Мэндсайхан-19 минут, П.Наранбаяр-06 минут, Ч.Номин-07 минут, С.Одонтуяа-1 цаг 54 минут, Б.Түвшин-09 минут, А.Ундраа-12 минут, Ч.Ундрэм-11 минут, Д.Цогтбаатар-43 минут, Ж.Чинбүрэн-05 минут, Л.Энх-Амгалан-01 минут, Ж.Энхбаяр-36 минут.

**Нэг.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Б.Энхмаа нар байлцав.

*Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.*

**Нэг.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал**

**С.Бямбацогт:** 1.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, А.Ариунзаяа, Ц.Баатархүү, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, Д.Ганмаа, О.Саранчулуун, С.Эрдэнэбат /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 19<sup>1</sup> дүгээр зүйлийн гарчгийн “шинжилгээний байгууллагын” гэснийг “шинжилгээ,

<sup>1</sup> Хуралдаан даргалагч ирцийг танилцуулах үед 7 гишүүн ирцэд нэмэгдсэн.

судалгааны ажлын” гэж, мөн заалтын 19<sup>1.1</sup> дэх хэсгийн “бүтээлийг” гэснийг “ажлын тайланг” гэж өөрчилж, “мэдээллийн” гэсний өмнө “цахим” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60  
Татгалзсан: 24  
Бүгд: 84  
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 19<sup>1.2</sup> дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19<sup>1.2</sup>.Үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, удирдлага зохион байгуулалт, ил тод, аюулгүй байдлыг хангах үүргийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 27  
Бүгд: 85  
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 19<sup>1.3</sup> дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19<sup>1.3</sup>.Эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэгч нь дараах мэдээллийг хуулиар нууцлахыг хориглосноос бусад тохиолдолд уг ажлыг дууссанаас хойш 90 хоногийн дотор үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд хүргүүлж, ил тод, хүртээмжтэй байлгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63  
Татгалзсан: 22  
Бүгд: 85  
74.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Б.Найдалаа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 23.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60  
Татгалзсан: 25  
Бүгд: 85  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 23.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59  
Татгалзсан: 26

Бүгд: 85  
69.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60  
Татгалзсан: 26  
Бүгд: 86  
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг бүхэлд хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 28  
Бүгд: 86  
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 22  
Бүгд: 87  
74.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**С.Бямбацогт:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.3.8 дахь заалтыг бүхэлд нь хасаж, мөн зүйлийн “дараах агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй” гэснийг “доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68  
Татгалзсан: 19  
Бүгд: 87  
78.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67  
Татгалзсан: 20  
Бүгд: 87  
77.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Гурав.Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**С.Бямбацогт:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66  
Татгалзсан: 21  
Бүгд: 87  
75.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /“Газарзүйн нэрийн жагсаалт батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Бад.Баярмаа нар байлцав.

*“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.*

**С.Бямбацогт:** “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 22  
Бүгд: 87  
74.7 хувийн саналаар дэмжигдлээ.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

*“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.*

**С.Бямбацогт:** “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 54  
Татгалзсан: 34  
Бүгд: 88  
61.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт хариулав. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /10:26/

*Уг асуудлыг 10 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв. Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Д.Амгалан, Ашигт малтмалын газрын тосны газрын Газрын тос боловсруулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чулуунбат, “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг, мөн компанийн Технологийн албаны дарга Б.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг танилцуулав.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 1 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ажлын 1 өдрийн завсарлага өгөв. /10:34/

***Тав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлт /Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Б.Галсанбат, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг Цэцийн гишүүн Д.Гангабаатар, уг дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нар танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, П.Сайнзориг, Б.Уянга, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал хариулж, тайлбар хийв.

**С.Бямбацогт:** 1.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “ .... шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх .... эрхтэй.” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	56
Татгалзсан:	38
Бүгд:	94

59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, П.Ганзориг нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул хуралдааны тэмдэглэлд саналаа дэмжсэнээр тэмдэглүүлэх санал гаргаж, 61.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 35

Бүгд: 94

62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 37

Бүгд: 94

60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх ...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 39  
Бүгд: 94  
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

*Уг асуудлыг 11 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.*

***Зургаа.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, референт Б.Баясах нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, М.Нарантуяа-Нара, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 11 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Долоо.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:56/

2.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай

холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:56/

*Уг асуудлыг 11 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.*

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургуулийн 10<sup>а</sup> ангийн багш, сурагчид, Баянхонгор аймгийн Богд сумын ерөнхий боловсролын сургуулийн 1980 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, С.Эрдэнэболд, Д.Батбаяр нарын урилгаар Төв аймгийн Эрдэнэсант сумын ерөнхий боловсролын сургуулийн 12<sup>б</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагайн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 12<sup>б</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 12<sup>б</sup> ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 1 цаг 56 минут үргэлжилж, 126 гишүүнээс 96 гишүүн хүрэлцэн ирж, 76.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 56 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГАЗРЫН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр, Баасан гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 00 минут.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлынхаа гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны ирц 126 гишүүнээс 71 гишүүн хүрэлцэн ирж 56,3 хувийн ирцтэй байна. Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн чуулганы хуралдааны ирцэд бүртгүүлсэн эхний 5 гишүүнээ танилцуулъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Батжаргалын Заяабал нарын гишүүд өглөө чуулганы хуралдаандаа хамгийн эрт ирсэн байна. Баяр хүргэе. Хаврын чуулганы төгсгөлд шагналтай.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 7 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Санал хураалтаар эхэлнэ шүү. Гишүүдийг ирцдээ орчхоод, чуулганы танхимдаа сууж байхыг хүсье. Санал хураалтаар эхэлнэ. Зарчмын зөрүүтэй 11 санал байгаа.

2 дугаарт нь “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

3 дугаарт “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

4.Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

5 дугаарт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

6-д Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

7-д баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно. Ийм 7 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.**

Тийм горимын санал байхгүй. Бичгээр өгөх ёстой.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана.

Бичиг ирээгүй Батбаатар гишүүн ээ. Та Байнгын хороо солих бичиг ирсэн. Даргын зөвлөлд орох бичиг ирсэн. Тэр чинь хэлэлцэх асуудалтай холбоогүй асуудал. Чуулганы хуралдаан дээр хэлэлцэх асуудалтай холбоотой үг хэлэхээр бол өмнөх өдрийн 17 цагаас өмнө яг энэ хэлэлцэх асуудлаар үг хэлнэ гэж бичиг ирүүлэх ёстой. Та бол Байнгын хороо, даргын зөвлөлд орох бичиг ирүүлсэн. Тийм болохоор энэ хэлэлцэх асуудалтай холбоогүй байна.

Зарчмын зөрүүтэй 11 санал байна. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалтад одоогоор 50 гишүүн бэлэн болсон байна. Бэлэн бус 31 гишүүн байна. Бэлэн бус байгаа гишүүд санал хураалтдаа бэлтгэлээ хангаарай. Хурууны хээгээ уншуулаарай. Бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт. Бүртгэлд ороогүй, ирцдээ ороогүй, санал хураалтдаа бэлтгэж амжаагүй гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. 126 гишүүнээс 82 гишүүн хүрэлцэн ирсэн байна. 46 гишүүн ирцийн санал хураалтад бэлэн болсон байна. 36 гишүүн бэлэн болоогүй байна шүү. Санал хураалт явуулна.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

### **Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал**

**Нэг.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 19<sup>1</sup> дүгээр зүйлийн гарчгийн “шинжилгээний байгууллагын” гэснийг “шинжилгээ, судалгааны ажлын” гэж, мөн заалтын 19<sup>1.1</sup> дэх хэсгийн “бүтээлийг” гэснийг “ажлын тайланг” гэж өөрчилж, “мэдээллийн” гэсний өмнө “цахим” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар, Аюушийн Ариунзаяа, Цэндийн Баатархүү, Дуламын Бум-Очир, Отгоны Саранчулуун, Жанчивын Галбадрах, Даваасамбуугийн Ганмаа, Сүхбаатарын Эрдэнэбат нарын гишүүд санал гаргасан байна. Цаашид “ажлын хэсэг” гэнэ. Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 84 гишүүн оролцоноос 60 гишүүн буюу 71,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 19<sup>1.2</sup> дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19<sup>1</sup>.2.Үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, удирдлага зохион байгуулалт, ил тод, аюулгүй байдлыг хангах үүргийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 85 гишүүн оролцсоноос 27 гишүүн буюу 31,8 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Уучлаарай. 85 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 68,2 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн байна.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 19<sup>1</sup>.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19<sup>1</sup>.3.Эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэгч нь дараах мэдээллийг хуулиар нууцлахыг хориглосноос бусад тохиолдолд уг ажлыг дууссанаас хойш 90 хоногийн дотор үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд хүргүүлж, ил тод, хүртээмжтэй байлгана.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 85 гишүүн оролцсоноос 63 гишүүн буюу 74,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 23.4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл, Найдалаа. Санал хураалт санал. Хураалтад 85 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 70,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 23.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 85 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 69,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар зүйлийг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 69,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Төслийн 4 дүгээр зүйлийг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 67,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 87 гишүүн санал хураалтад оролцсоноос 65 гишүүн буюу 74,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

**Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.3.8 дахь заалтыг бүхэлд нь хасаж, мөн зүйлийн “дараах агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй” гэснийг “доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 87 гишүүн санал хураалтад оролцсоноос 68 гишүүн буюу 78,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 67 гишүүн буюу 77,0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

**Гурав.Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт санал. Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 75,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Хууль санаачилсан Болдын Уянга гишүүн, Рэгдэл гишүүн, Хосбаяр нарын гишүүддээ бас талархал илэрхийлж байна. Ажлын хэсэг бас манай Сархадын Зулпхар гишүүн бас ажлын хэсгийг ахалж ажилласан.

10.15 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

**“Тогтоолыг хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгээ үргэлжлүүлэн явуулна.**

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжих талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. 61 гишүүн санал хураалтдаа бэлэн болсон байна. 26 гишүүн санал хураалтдаа бэлтгэе.

Нөгөө “Газар зүйн нэрсийн жагсаалт батлах тухай” Засгийн газраас өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл байгаа. Санал хураалтыг явуулъя.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 74,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

“Тогтоолын хавсралт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

10.17 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

### **“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.1.3-д “Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу ирүүлсэн саналыг нэгтгэн, нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж, Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах” гэж заасны дагуу “Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг та бүхэнд уншиж танилцуулсан.

Одоо “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя. Гишүүд суудалдаа суухыг урьж байна.

1.“Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 54 гишүүн буюу 61,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа. Улсын Их Хурлын гишүүддээ талархал илэрхийлье. Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Эцсийн найруулга дээр. Батбаатар гишүүн.

Түр хүлээж байгаарай. Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургуулийн 10<sup>а</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Амьдралд нь аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе. Хүүхдүүддээ баярлалаа. Их өвөрмөц мэндчилгээ дэвшүүлсэн та бүхэндээ баярлалаа.

Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр Батын Батбаатар гишүүн саналаа хэлье.

**Б.Батбаатар:** Үг хэлэх, асуулт асуухаар нэр ирүүлсэнгүй гээд хэлэлцэх асуудалтай холбоотой асуудал дээр асуултын маань асуулт болсонгүй. Байнгын хорооны бүрэлдэхүүн дээр Ардын намын бүлгийн дарга Батжаргал бичгээ л өгсөн. Асуулт асуух, үг хэлэх зүйл бичээгүй. Тэгэнгүүт танд үг байгаа юу, өөрчлөлт байгаа юу гэж өчигдрийн чуулган дээр асууж байгаад өнөөдөр ингээд санал хураалгаж байна. Ардчилсан намын бүлгийн даргын бичгээр бас Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж байна. Иргэний зориг ногоон намын даргын бичгээр Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлтийг оруулахгүй байна. Их Хурлын дарга аа, Их Хурлын дарга болохдоо юу юу гэж ярьж байлаа. Эхэлсэн алхам чинь, анхны ажлууд чинь ингээд хэлж байсан, амлаж байсан зарчим, ёс зүй ярьж байсан чинь яагаад алдагдаад унав. 2 дахь өдөр Иргэний Зориг ногоон намын даргын өрөөнд Замира гишүүн, Нара гишүүн бид 3 хуралдаад, Батболд ирээгүй, дуудаад ирээгүй, мессеж бичээд ирээгүй. Улсын Их Хурал дахь Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахаар саналуудаа гаргаад, ярилцаад, тэгээд тэр дагуу албан тоотыг өөрийн чинь нэр дээр өнгөрсөн 3 дахь өдөр явуулсан. Ардын нам, Ардчилсан намын бүлгийн дарга нарын бичгийг болохоор хүлээж аваад, уншаад, алх тогшоод, санал хураалгачихдаг. Бусдыг нь ингээд хүлээж авахгүй, уншихгүй байх юм уу цаашдаа. Яагаад энэ асуудлыг уншихгүй орхиж байгаа юм бэ гэдгийг дахин асууж байна. Цаашид хамтарч ажиллахын тулд бас Ардчилсан намын бүлгийн даргад хүсэлт тавьж байна. Энэ асуудалтай холбоотойгоор завсарлага авч өгөөч. Бидний өмнөөс. Бидэнд бүлгийн эрх байхгүй байгаад байна.

Ингээд Байнгын хорооны бүрэлдэхүүнд орох нөгөө оногдсон квотынхоо дагуу орох асуудлыг Их Хурлын дарга нь одоогоос ингээд цөөнхөө буюу энэ чинь ард түмний тодорхой хэсэг шүү дээ. Цөөнхөө олонхын хүчээр юм уу, алхны хүчээр дарангуйлаад эхэлбэл цаашаа явахгүй. Цаашаа явахгүй. Тийм болохоор Их Хурлын дарга энэ асуудлаа эцсийн найруулга дээрээ миний өгсөн саналын дагуу, Их Хурлын гишүүдийн өгсөн саналын дагуу эцсийн найруулга дээр энэ асуудлаа засаж оруулаач ээ. Энд хариулж өгөөч. Ардчилсан намын бүлгийн даргад тавьсан хүсэлтийг анхаарч өгнө үү.

**С.Бямбацогт:** Батын Батбаатар гишүүний бас асуулт уг нь эцсийн найруулгын санал хийх ёстой. Гэхдээ асуултад хариулчихъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээр бас Байнгын хорооны бүрэлдэхүүнтэй холбоотой журам байгаа. Энэ журам дараах журмыг баримтална гээд гишүүн Байнгын хороонд харьяалагдах саналаа нам, эвслийн бүлэгт, бүлэгт харьяалагддаг гишүүн саналаа Улсын Их Хурлын даргад хүргүүлнэ гэж. Тийм болохоор Улсын Их Хуралд албан ёсоор 2 бүлэг байгаа. Ардын намын бүлэг, Ардчилсан намын бүлэг. Тэгээд Ардын намын бүлгийн гишүүд Ардын намын бүлэгтээ, Ардчилсан намын бүлгийн гишүүд Ардчилсан намын бүлэгт нь аль Байнгын хороонд харьяалагдах хүсэлтээ бичгээр өгнө. Тэр хүсэлтийг нь нэгтгээд зохицуулаад, Улсын Их Хурлын даргад бүлэг төлөөлж бүлгийн дарга нар бичгээр ирүүлнэ. Бүлэггүй гишүүд бол Улсын Их Хурлын даргад өөрсдөө шууд хүсэлтээ ирүүлнэ. Дэгийн тухай хууль дээр ингээд биччихсэн байгаа. Үүний дагуу та хүсэлтээ бичгээр ирүүлсэн. Та Аюулгүй байдал, гадаад бодлого байнгын хороонд оруулъя гэж бичгээр 2026 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлээд Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороонд та орсон байгаа. Та бас өөр Батболд гишүүнийг баахан Байнгын хорооноос гаргая гэсэн хүсэлт ирүүлсэн байна

лээ. Тийм болохоор тэр бол боломжгүй. Хууль зөрчинө. Эрхээ эдэлж болно тэр 2 гишүүн. Тийм хүсэлт ирээгүй. Баярлалаа.

Дэгийн тухай хуулиа та судлаад, Дэгийн тухай хуулийнхаа дагуу бас гишүүд маань асуудалд хандаарай. Тэгээд энд бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын Тамгын газар энэ зохицуулалтыг хийж, холбогдох хуульд нийцүүлж журмууд ирсэн. Нэг гишүүний эрх нөгөө гишүүний эрхээр хязгаарлагдаж болохгүй. Нэг гишүүнийхээ эрхийг хязгаарласан хүсэлтийг та ирүүлж болохгүй.

Байнгын хорооны тогтоол дээр эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.26 цаг.

### **Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзориг танилцуулна. Индэрт урьж байна.

**П.Ганзориг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүнээс 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс гарсан санал болох “орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөх боломжтой, эдийн засгийн үр ашиг бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэх, үүнд Засгийн газар баталгаа гаргаж болох” агуулга бүхий саналыг хуралдаан даргалагчаас санал хураалт явуулахгүйгээр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед тухайн саналыг Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн холбогдох зохицуулалтуудад нийцүүлэн “Дунд хугацаанд хэрэгжүүлэх төслийн орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөх боломжтой, эдийн засгийн үр ашиг бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг нэгдсэн төсөвт нөлөө үзүүлэхгүйгээр санхүүжүүлэх чиглэлийг баримтална” гэсэн агуулгаар өөрчлөн найруулах санал гаргасныг Монгол Улсын Их Хурлын

чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасныг үндэслэн санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусгасан төслийн эцсийн хувилбар болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн хэсэг. Ганболдын Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Огнонгийн Хуягцогт Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Түмэндалайн Даваадалай Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Маамбын Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Лхагвадоржийн Эрдэнэбадрах Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Дүгэржавын Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Чулуундаваагийн Чулуунбат Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тос боловсруулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Уранбаатарын Чинзориг “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн Гэрээ, эрх зүйн газрын дарга, Бямбын Мөнх-Эрдэнэ “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн Технологийн албаны дарга. Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн гишүүдэд бас нэг хууль уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д “нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан болон бусад этгээд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.” 21.25-д “нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглосон” заалттай шүү.

Мөн Улсын Их Хурлын тухай хуулийн 21.31-д “чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.” Ийм хуулийн заалтууд байгаа. Тийм

болохоор та бүхэн үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх ёстой. Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандах ёстой шүү гэдгийг та бүхэндээ бас сануулъя.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэгт болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл даргад микрофон өгье.

**О.Цогтгэрэл:** Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Энэ гадаад зээлийн үр агшиг, ашиглалтыг нэмэгдүүлэх гээд их гоё нэртэй хуулийн төсөл явж байгаа. Энэ хуулийн төсөл дээр тодорхой байр суурь илэрхийлэхгүй бол бас болохгүй болоод байна. Нэр нь их гоё. Үүний цаана Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, өр зээлийн хязгаар, олон олон зүйлүүдийг үндсэндээ энэ хуулийн гадуур гаргах, Монгол Улсыг 2 төсөвтэй болгох үзэл санаа энэ хуулийн цаана агуулагдаж байгаа. Яг энэ хуулийн хүрээнд яригдаж байгаа энэ 3 төслийн хүрээнд 3,5 тэрбум долларыг Монгол Улсын өрөнд тооцохгүй байчихъя. Төсвийн хязгааруудад тооцохгүй байчихъя. Тэр тусмаа орон нутгийн төсвүүдийн хязгааруудад ч хамааралгүй болгочихъё гэж байгаа. Үнэхээр энэ бол бас ингээд зарчмын хувьд олон олон талаасаа байж боломгүй, нөгөө талаас энийг маш их нухацтай судалж үзэх ёстой ийм асуудал болж хувирч байна. 3,5 тэрбум доллар 10 их наяд төгрөгийг төсвийн хүрээ хязгаар, өр, төсвийн тогтвортой байдлын хуулиуд энэ бүх хуулиудын хүрээ хязгаараас гаргачихъя. Ер нь бол Монгол Улсын өрөнд тооцохоо байчихъя. Өрийг ийм хэмжээгээр нэмэгдүүлчихье. Энэ нь өөрөө хуулиас гадуур байг. Монгол Улсын Их Хурал дээр батлагдсан нэгдсэн төсвийн хүрээ хязгаарууд биш, ерөөсөө ингээд өр зээлийг дураараа нэмдэг болъё. 3 төсөлд зориулж тусгайлсан хууль гаргая гэдэг энэ үзэл санаа бол үнэхээр нягтлан шалгах ёстой зүйл үүний цаана агуулагдаж байна.

Тийм учраас Ардчилсан намын бүлгээс энэ асуудал дээр, энэ хуулийн төсөл дээр ажлын 1 хоногийн завсарлага өгөөч ээ. Бид бүгд энэ асуудлыг ирэх 1 дэхийн бүлгийн хурлаар онцгойлон нухацтай хэлэлцэх шаардлагатай байна Энэ ер нь тийм яаран сандран хийх биш, энийг тал талаасаа Улсын Их Хурлын гишүүдэд ч гэсэн мэдээлэл авч нухацтай хэлэлцэх ёстой асуудал шүү гэдгийг бас онцгойлон хэлье.

Их Хурлын дарга завсарлага өгөхийг хүсье.

**С.Бямбацогт:** Завсарлагын хугацаа. 1 хоногийн хугацаатай завсарлага Ардчилсан намын бүлэгт өглөө.

10.34 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.**

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Дашбалбарын Гангабаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Д.Гангабаатар:** Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Т.Баясгалан даргалж...

**С.Бямбацогт:** Микрофоноо ойртуулаарай.

**Д.Гангабаатар:** Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Т.Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар, илтгэгч О.Мөнхсайхан, Б.Болдбаатар, Р.Батрагчаа нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлтээ хийлээ.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд хүсэлт гаргагч Монгол Улсын дээд шүүхийн итгэмжилсэн төлөөлөгч, Улсын дээд шүүхийн шүүгч Д.Батбаатар, Ц.Цогт нар оролцлоо.

Энэхүү хуралдаанаар Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.6, 8.7, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх заалт, 47 дугаар зүйлийн 1, 48 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 50 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлт нь нийт 22 нүүр, түүний үндэслэл хэсэг нь дангаараа 13 нүүр болсон учраас та бүхэнд дүгнэлтийн үндэслэл хэсгийг товчилж, тогтоох хэсгийг бүхэлд нь уншиж сонсгоё.

Үндэслэл.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн маргаан бүхий зохицуулалтаар Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх чиг үүргийг Монгол Улсын дээд шүүхэд олгожээ. Шүүхийн үндсэн чиг үүргийн агуулгад харшлахуйц гүйцэтгэх эрх мэдэлд хамаарах чиг үүргийг олгосон нь төрийн эрх мэдэлд хуваарилах зарчим болон Үндсэн хуулийн зарим заалтыг тус тус зөрчсөн гэж үзэн Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргасан.

Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гээд 5 дахь заалтад хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх гэж Үндсэн хуулийн дэг журмыг бэхжүүлэх, шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангах, шүүн таслах үйл ажиллагааг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай бөгөөд шүүх эрх мэдлийн цөмд харшлахгүй бүрэн эрхийг Улсын дээд Шүүхэд хуулиар олгохыг зөвшөөрсөн байна.

Гэвч уг заалтыг ямар нэг хязгааргүй хэрэгжүүлбэл Үндсэн хуулийн 3 дугаар бүлэгт тогтоосон төрийн эрх мэдлийн хуваарилалт алдагдахад хүрнэ. Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх чиг үүрэг нь Улсын дээд шүүхийн үндсэн бүрэн эрхтэй

хамааралгүй байх, шүүхийн үндсэн бүрэн эрхэд харшгүй байх зарчимд нийцсэн байхыг шаардана. Энэхүү зарчим нь Монгол Улсын Үндсэн хуулиас урган гарч буй зарчим бөгөөд шүүхэд олгосон чиг үүрэг нь бусад эрх мэдлийн бүрэн эрх биш байх, шүүх хэрэгжүүлэхэд илүү зохимжтой байх, шүүхийн бие даасан байдлыг хангасан байх, шүүх үндсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулахгүй байх зэрэг шалгуур тавигдана. Төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн нэгдсэн холбоодын бүртгэл нь улсын эдийн засгийн бодлоготой холбоотой гэж үзэх үндэслэлтэй.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 10 дахь заалтын дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэл нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд багтдаг. Иймд Мэргэжлийн нэгдсэн холбооны бүртгэлд төрийн бодлого хэрэгжүүлэх, хуулийн биелэлтийг хангах, гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүргийн хүрээнд хамаарч байх тул бусад эрх мэдлийн бүрэн эрх биш байх шалгуурыг хангахгүй байна.

Үндсэн хуулийн дэг журмыг бэхжүүлэх шаардлагын үүднээс бие даасан тал үл харах шүүх эрх мэдлийн байгууллага хэрэгжүүлэх нь илүү зохимжтой чиг үүргийг Улсын дээд шүүхэд олгохыг Үндсэн хуулиар зөвшөөрсөн боловч Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх чиг үүрэг нь шүүх эрх мэдлийн байгууллага хэрэгжүүлэхэд зохимжтой чиг үүрэг биш байна. Учир нь шүүх эрх мэдлийн байгууллагаас гаргасан аливаа шийдвэр хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд үндэслэдэг. Харин хуулийн зохицуулалт тодорхойгүй байх нь бодлогын сонголт хийх буюу үзэмжээрээ шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхтэй холбоотой зохицуулалт нь хуульд заасан шаардлагын аль нэгийг бодлогын хувьд сонгох боломжийг бүрдүүлсэн зохицуулалт байна.

Тухайлбал, 5 дугаар зүйлийн 5.3,1, 5.3,2 дахь заалтад заасан Мэргэжлийн нэгдсэн холбоонд тавигдах шаардлагыг тусгасан мэргэжлийн холбоодын олонхын төлөөлөл бүхий гишүүд үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтаар зах зээлийн 50-аас дээш хувийг эзлэх, эсхүл тэдгээрийн аль 1 шаардлагыг хангах, ямар хугацаанд хамаарах тоон мэдээллийг ашиглах нь тодорхойгүй байх тул эрх зүйн тодорхой байдлын зарчмыг хангаагүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Тиймээс зах зээлд эзлэх хувийг тогтоох зохицуулалт тодорхойгүй, хоёрдмол утгатай байхаас гадна шүүх эрх мэдлийн байгууллагад бодлогын сонголт хийх нөхцөлийг бүрдүүлсэн байх тул шүүх хэрэгжүүлэхэд илүү зохимжтой чиг үүрэг гэж үзэх үндэслэлгүй байна.

Үндсэн хуулийн 3 дугаар бүлэгт төрийн эрх мэдлийг хуваарилахдаа шүүх эрх мэдэл нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хөндлөнгийн нөлөөллөөс ангид байх, бие даасан байх зарчмыг тусгасан. Шүүх эрх мэдэл хүний нөөц болон чиг үүргийн хувьд бусад эрх мэдлээс бие даасан байх, шударга шүүхээр шүүлгэх эрхийн баталгаа болдог. Улсын дээд шүүх хууль тогтоох эсвэл гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүргийг хэрэгжүүлэх нь шүүхийн бие даасан байдал, үр нөлөөтэй хяналтыг сулруулах эрсдэлтэй. Шүүхийн бие даасан байдал нь шүүх хэрэг маргааныг гагцхүү хуульд захирагдан хараат бусаар тал үл харан хянан шийдвэрлэх, иргэдийн итгэлийг хамгаалдаг. Энэ итгэлээс шүүх эрх мэдэл нь легитим шинжээ олж авдаг. Шүүх улс төрийн бодлогын асуудалд оролцох, бүрэн эрхээ хууль тогтоох, гүйцэтгэх

эрх мэдлийн оролцоо заавар зөвлөмжөөр хэрэгжүүлэх нь түүний бие даасан тал үл харах байдалд иргэдийн итгэх итгэлийг бууруулдаг.

Уг хуулийн зохицуулалт үйлчилж эхэлснээс хойш мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх талаар Улсын дээд шүүхэд ирүүлсэн зарим хүсэлтэд хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтад заасан үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалт нь тухайн салбарын зах зээлийн 50-аас дээш хувийг эзэлдэг байх шаардлагад холбогдуулан гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас Улсын дээд шүүхэд хандсан албан бичиг гаргуулан авсан байна.

Хуулийн шаардлагыг хангасан эсэхийг яам, агентлагийн албан бичигт үндэслэн шийдсэн гэж ойлгогдохуйц нөхцөлийг бүрдүүлж байгаа нь шүүх бие даасан гэж итгэх иргэдийн итгэлийг алдагдуулах эрсдэлийг үүсгэжээ.

Энд мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх чиг үүргийг Улсын дээд Шүүх хэрэгжүүлэх нь шүүхийн бие даасан байдлын зарчим, Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт нийцээгүй байна. Шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар хэрэгжүүлэх Улсын дээд шүүхийн бүрэн эрх нь шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөө, хүртээмж зэрэгт сөрөг нөлөө үзүүлэхээр байж болохгүй. Хуулиар олгосон чиг үүрэг нь үндсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөхүйц хэмжээнд Улсын дээд шүүхийн ачааллыг нэмэгдүүлэхээр бол Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нийцэхгүй.

Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх Улсын дээд шүүхийн болон түүний шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх үндсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж, улмаар шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөө, хүртээмжийг бууруулахаар байна. Иймд хуулиар олгосон бүртгэлийн чиг үүрэг Улсын дээд шүүхийн үндсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх нь саад учруулахгүй байх шалгуурыг хангаагүй байна.

Иргэн Монгол Улсын хууль олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрхтэй. Хуульд мэргэжлийн нэгдсэн холбоог байгуулах, бүртгүүлэх, санхүүжилт бүрдүүлэх болон тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх талаар зохицуулж, субъектив эрхийг тусгасан боловч тус эрх нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах боломжгүй байна. Тиймээс Үндсэн хуулиар баталгаажуулсан шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарласан тохирсон байх зарчмын зайлшгүй тэнцвэртэй байх шалгуурыг хангаагүй тул шүүхэд гомдол гаргах эрхийг зөрчсөн байна.

Шүүхэд гомдол гаргах эрхийг бүрэн хязгаарласан тохиолдолд шударга шүүхээр шүүлгэх эрхийг эдлэх боломжгүй бөгөөд маргаан бүхий хуулийн зохицуулалтын хувьд шүүхэд гомдол гаргах эрхийг зөрчсөн нь шударга шүүхээр шүүлгэх эрхийн зөрчлийн шинжийг давхар агуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон Монгол Улсын үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.” 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзурга дугаар зүйлийн 14 дэх заалтад “ ... шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх эрхтэй. ...”, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.” гэж заасанд нийцээгүй байна.

2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд Шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.” 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заалтад “шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй.” гэж заасныг зөрч заасныг зөрчөөгүй байна.

3.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.” 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар...” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2026 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Г.Баясгалан, гишүүд Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Б.Болдбаатар, Р.Батрагчаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Гангабаатар Үндсэн хуулийн цэцийн гишүүнд баярлалаа. Танилцуулга хийсэн.

Баянхонгор аймгийн Богд сумын ерөнхий боловсролын сургуулийн 1980 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Манай Баянхонгор аймгийн нутгийн гишүүд бас хамт уулзаад, хамт танилцаж байна. Даваагийн Цогтбаатар гишүүн, Жаргалсайхан гишүүд маань танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна. Индэрт урьж байна.

**Х.Тэмүүжин:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 02 дугаар дүгнэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар танилцуулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар итгэмжилсэн төлөөлөгчөөс Үндсэн хуулийн цэц мэргэжлийн нэгдсэн холбоог бусад холбоо, хуулийн этгээдээс ялгаатай гэдгийг онцолж тайлбар үндэслэл өгсөн эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй бөгөөд Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, хуулийг боловсронгуй болгож, сайжруулах нь зүйтэй талаар үг хэлсэн болно.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд Шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.” 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дугаар хэсэгт “... Улсын дээд шүүх...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй.” Монгол Улсын үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.” гэж заасанд тус тус нийцээгүй байна гэсэн Монгол Улс Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.2 дахь заалтын дагуу хэсэг, заалт бүрээр санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүнд танилцуулга хийсэнд баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг танилцуулна. Индэрт урьж байна.

**М.Энхцэцэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Эдийн засгийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийн агуулгыг танилцуулсан болно.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн Үндсэн хуулийн цэцэд гаргасан хүсэлт цэцийн дүгнэлтийн хүрээ хязгаарын талаар болон Монголын нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг Мэргэжлийн холбоод хэт олширч зарим нь хувь хүний хяналтад орсноор гишүүдийн эрх ашгийг хамгаалахгүй байх, санхүүгийн зөрчилтэй үйл ажиллагаа явуулах зэрэг сөрөг үр дагаврууд гарч байгаа тул салбарын эрх зүйн орчныг иж бүрэн шинэчлэх замаар мэргэжлийн холбоодын үйл ажиллагаа болон санхүүгийн ил тод байдлыг цэгцлэн сайжруулах зайлшгүй шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж мэргэжлийн болон спортын холбоод олноор давхардсан байдлаар байгуулагдаж, хоорондын зөрчил маргаан нэмэгдэж байгаа тул мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг зохистойгоор цэгцлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар үг хэлсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.2 дахь заалтын дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулахад Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулагдсанаас хойш 30 хоногийн дотор Улсын дээд Шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.” 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй.” Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны

эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.”, 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх” гэснийг зөрчсөн байна гэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж.

**С.Бямбацогт:** Мөнхчулууны Энхцэцэг гишүүнд баярлалаа. Одоо Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Болдын Уянга гишүүн асуултаа асууя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирцийн дарааллаараа, өглөө ирсэн ирцийн дарааллаараа асууна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаас хойш бас маш олон асуудлууд цэгцэрч байгаа. Би Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байсан. Аялал жуулчлалын тухай хуулийг 20 жилийн дараагаар шинэчилсэн найруулга хийж, аялал жуулчлалын мэргэжлийн холбоог бид нар бас байгуулж байсан. 24 холбоо нэгдэж, энэ мэргэжлийн холбоог байгуулж нэлээн үр дүнтэй явж байгаа мэргэжлийн холбоодын 1 болов уу гэж бас бодож байгаа. Цаашдаа манай ойн салбар дээр бас маш олон холбоод байгаа. Энэ ойн салбар дээр байгаа холбоод маань бас мэргэжлийн нэгдсэн холбоо болох энэ чиг баримжаа руугаа явж байгаа. Тэгээд бид нар энэ Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хууль бол их зөв хууль бас гарсан гэж яг амьдрал дээр хэрэгжүүлээд явж байсан хүний хувьд бол бодож байна. Цаашдаа бид нар Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хуулийг мэдээж сайжруулах зүйлс байвал сайжруулаад, тодорхой гарч байгаа асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд шийдвэрлээд явах бүрэн дүүрэн боломжтой гэж үзэж байгаа. Тэгээд Эдийн засгийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороогоор энэ асуудлууд нь ороод явж байгаа учраас бас мэргэжлийн Байнгын холбоодынхоо саналыг бол дэмжиж байна.

Тэгэхдээ нэгдсэн 1 ойлголтыг ард түмэндээ иргэддээ ялангуяа энэ холбоодод их зөв хүргэхгүй бол болохгүй байгаа. Ялангуяа санхүүгийн харилцааны хувьд энэ асуудлыг нэг мөр шийдвэрлэхгүй бол их төвөгтэй үйл ажиллагаанууд үүсэж байгаа. Тухайлах юм бол бусад улс орнуудад мэргэжлийн нэгдсэн холбоо, магадгүй холбоодын нэгдэл холбоо байх эсвэл аж ахуйн нэгжүүдийг нийлүүлсэн холбоо байх гэдэг утга агуулгаар яваад байгаа юм. Манайх нийцлийн хэлбэр дээр яваад байгаа юм. Нийцлийн хэлбэр дээр явж байгаа учраас энд ямар асуудлууд үүсээд байгаа вэ гэхээр бүх холбоод нь нэгдээд, дээрээс нь аж ахуйн нэгжүүд тухайн холбоондоо нэгдээд ороод ингээд явахаар давхардсан татварын асуудлууд нэг талдаа үүсэж байна. Тэгэхээр бид нар энэ санхүүгийнх нь асуудлыг нэг мөр шийдвэрлэхгүй бол давхардсан татвартай холбоотой асуудлууд цаашдаа илүү их үүсээд явах, эргээд

нөгөө тухайн холбоонд нэгдэж байгаа холбоод болон аж ахуйн нэгжүүд дээр бол дарамт шахалт үүсэх нөхцөл байдал бий болж байгаа.

Мэргэжлийн нэгдсэн холбоодыг үүсгэж байгаа гол суурь шалтгаан бол төрийн чиг үүргийг хэсэгчлэн болон бүхэлд нь шилжүүлэхтэй холбоотой харилцааг шийдвэрлэе. Энэ өөрөө төрд бас нөгөө талдаа хувийн хэвшил рүү төрийн үйл ажиллагааг шилжүүлэхтэй холбоотой маш зөв заалт, зөв зарчим гэж ойлгож байгаа. Гэтэл мэргэжлийн холбоод дээр маань тодорхой хэмжээнд иймэрхүү асуудлууд бас үүсээд байгаа учраас энийг бид нар бас нэгэнт л тодорхой хэмжээний өөрчлөлтүүд хийгээд явахад цаашдаа бид нар бас анхаарах ёстой болов уу гэсэн ийм бодолтой байгаа. Тэгэхээр санхүүгийн асуудлыг бол бид нар зайлшгүй бас харж үзэх ёстой юм байна лээ гэдэг саналыг хэлэх гэж байгаа юм. Асуулт бол алга. Дэмжиж байна.

**С.Бямбацогт:** Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн санал хэллээ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууя.

**П.Сайнзориг:** Мэргэжлийн нэгдсэн холбоотой холбоотойгоор Үндсэн хуулийн цэцээс гаргасан энэ дүгнэлтийг бид нар хүлээж аваад, хуулиа бол сайжруулаад явах нь зүйтэй байх. Ер нь зүгээр мэргэжлийн нэгдсэн холбоо гэдгээ бид буруу ойлгоод байна. Сая Бат-Эрдэнэ гишүүн бас зөв гээд хэлээд байгаа боловч эрх зүйн байдал буюу ажиллах орчны хувьд бол одоо хүртэл дутагдалтай байна. Ер нь зүгээр хуультай энэ мэргэжлийн холбоод ажиллаад байгаа юм. Өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбоо, Нягтлан бодох бүртгэлийн институт, Нотариатын танхим, Хөрөнгийн үнэлгээчдийн холбоо аялал жуулчлалын холбоо гээд дандаа хууль, эрх зүйн зохицуулалттай. Тухайн салбарын хуулиуд дээрээ. Түүнээс биш бусад мэргэжлийн холбоод бол үндсэндээ нэг цүнх барьсан хэсэг бүлэг тамгатай л хүмүүс байгаа шүү дээ. Яг тухайн салбарынхаа харьцангуй олонхыг бол нэгтгээд явж байгаа мэргэжлийн холбоо гээд явахад бол хүнд, хэцүү. Тэгэхээр энэ хууль уг нь бол зөв гарвал их зөв байгаа юм. Тэгэхээр яах аргагүй Улсын дээд шүүхэд энэ мэргэжлийн холбооны бүртгэлийг өгнө гэдэг бол боломжгүй л дээ. Энэ холбоотой холбоотой үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгахтай холбоотой харилцаан дээр гарсан гомдлыг дараа нь Улсын дээд шүүх бүртгэлээ гэхэд Улсын дээд шүүх өөрөө өөрийнхөө шийдвэр дээр гомдол авна гэж байхгүй. Тэгэхээр энэ чинь ингээд маш том ноцтой үр дагаврууд бий болгочхож байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ бол зайлшгүй засаад явах нь зөв байгаа юм.

Ер нь аж ахуйн нэгж, байгууллага буюу эдийн засгийн чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа энэ хүмүүс чинь танхим дээр л нэгдэх ёстой юм байгаа юм. Уг нь холбоо дээр биш. Жишиг нь энэ юм. Холбоо гэдэг бол цаашдаа картель үүсгэнэ. Нийтлэг эрх ашгаа ярихгүй. Яг холбооны гишүүн буюу тэр аж ахуйн нэгж, байгууллагуудын явцын эрх ашгийг хамгаална л гэсэн үг. Танхим гэдэг бол дэлхий нийтээр явсан загвар бөгөөд тухайн салбарын нийтлэг эрх ашиг, стандартыг сайжруулах, төртэй яаж харьцах вэ, төрийн бодлогод тухайн салбарын бодлого шийдвэрийг яаж тусгуулах вэ гэдэг албан ёсны лобби хийдэг ийм механизм.

Тэгэхээр ер нь зүгээр энэ манай мэргэжлийн холбооны байгуулъя гэсэн салбарууд маань ер нь Худалдаа аж үйлдвэрийн танхим дээрээ яг тухайн салбарынхаа танхимыг байгуулаад, шат шатанд нь үйл ажиллагаа явуулж сураач гэдэг зүйлийг би бас уриалмаар байгаа юм.

Эцэст нь 1 зүйл байна. Энэ Цэцийн шийдвэрийн үр дагавар байгаа. Улсын дээд шүүх бас цаагуураа нэг зүйлийг хэлээд байна. Юу вэ гэхээр энэ улс төрийн намын бүртгэлийг чинь Улсын дээд шүүх хийж байгаа нь буруу байна шүү гэдэг зүйлийг энэ хуулиараа дамжуулж хэлж байгаа байхгүй юу. Ер нь зөв. Тэгэхээр энэ улс төрийн намын бүртгэлийг цаашдаа Сонгуулийн ерөнхий хороо нь байдаг юм уу, энэ зүйлээсээ бид нар анхаарах ёстой. Энэ дээр тэгэхээр Улсын Их Хурлыг хэн төлөөлж оролцсон билээ. Тэр гишүүн маань бас хариулж өгөөч. Ер нь яах бодолтой байна. Энэ Улсын дээд шүүх энэ хүсэлтийг гаргахдаа ер нь цаад санаа агуулга нь юу байсан бэ. Энэ зүйл дээр хариулт аваадахъя. Тэгээд би бас тодруулж асууя.

**С.Бямбацогт:** Хариулах уу. Үндсэн хуулийн цэц дээр итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Батнайрамдал гишүүн асуултад хариулъя.

**О.Батнайрамдал:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Зарчмын хувьд бол тантай санал нэг байна. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт дээр бол нэг ёсондоо Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1 дээр Мэргэжлийн нэгдсэн холбоодын үүсгэн байгуулснаас хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүх дээр бүртгэнэ гэсэн нь нэг ёсондоо тайлбартаа бол Үндсэн хуулийн зөрчилтэй байна гэж гаргасан байгаа юм.

Мөн энэхүү тайлбарт бас таны нэмэлт асуулттай холбоотойгоор үндэслэлээ бас тайлбарласан байна. Ер нь ашгийн болон ашгийн бус үйл ажиллагаа явуулж байгаа, мөн эдийн засгийн салбарын хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй этгээдүүдийн нэгдсэн холбоо нь худалдаа, бизнес, эдийн засгийн өргөн хүрээний харилцаанд бие даан орох, мөн ашгийн болон ашгийн бус үйл ажиллагаа явуулж байгаа ийм хуулийн этгээдийн үүсгэн байгуулахтай холбоотой харилцаанд Улсын дээд шүүх оролцох нь эрх зүйн онолын болон хууль зүйн чиг үүргийн хувьд тохирохгүй төдийгүй шүүх эрх мэдлийн чиг үүргийн хувьд зөрчилдөх үр дагавар үүсгэхээр байна гэсэн байгаа юм.

Тэгэхээр энэ мэргэжлийн холбоод бол яг хуулийн этгээдийн хүрээнд бол төрийн бус байгууллага. Таны хэлсэн бас яг одоо Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25.8-д зааснаар бол улс төрийн намын бүртгэл бол Улсын дээд шүүх дээр бол явдаг байгаа. Бас хуулийн этгээдийн хүрээнд бол энэ чинь бас төрийн бус байгууллага гэж бүртгэгдэж байгаа шүү дээ. Үүнийгээ бас ялгааг нь тайлбарлахдаа дараах байдлаар тайлбарласан байгаа юм. Улс төрийн намыг бүртгэх чиг үүрэг нь иргэдийн улс төрийн үзэл бодлоороо чөлөөтэй эвлэлдэн нэгдэх үндсэн эрхийг хангах, Үндсэн хуульд заасан төрийн эрх мэдлийг ард түмний мэдэлд байх зарчим, иргэд улс төрийн нам байгуулж эс үгүй бол намд элсэн нэгдэх замаар төрийн удирдах, оролцох эрхийн баталгааг хангахад Улсын дээд шүүх оролцох ийм агуулгатай бас тайлбарласан байгаа юм.

Бас нэмээд хүний эрхийг ноцтой зөрчсөн, ялгаварлан гадуурхсан, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэлд ноцтой аюул учруулахуйц хууль бус үйл ажиллагаа явуулах улс төрийн намыг бүртгэхээс татгалзах. Ийм хууль бус үйл ажиллагаа явуулж буй намыг тараах, улмаар төрийн эрх барих дээд байгууллагыг нийтээрээ чөлөөтэй сонгох эрхийг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй оролцдог улс төрийн намыг бүртгэх үйл ажиллагааг түдгэлзүүлэх, тараах эсэх асуудлыг хөндлөнгийн нөлөөлөлгүйгээр хараат бусаар шийдвэрлэх шаардлагын үүднээс гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд бус

Улсын дээд шүүхийн хүрээнд хуралдаанаар харьяалуулсан гэж үздэг гэж тайлбарласан байгаа юм.

Гэхдээ энийг магадгүй бид нар бас цаашаагаа авч үзэх шаардлагатай байх. Хоёулаа хуулийн этгээдийн хүрээнд явж байгаа. Бас мөн хэдийгээр улсын төрийн эрх байх дээд байгууллагыг нийтээрээ чөлөөтэй сонгох энэ эрхийг хэрэгжүүлэхэд хараат бусаар шийдвэрлэхэд Улсын дээд шүүх оролцож байгаа боловч бас олон улсын жишгийг энэ дээр харах нь зүйтэй байх гэж бодож байгаа. Гэхдээ энэ яах вэ бас ялгаатай нь нэмэлт тайлбараар бас Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтдээ бол тусгаж өгсөн байгаа юм.

**С.Бямбацогт:** Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

**П.Сайнзориг:** Тэгэхээр шинэ спикер бас яг энэ рүү анхаармаар байгаа юм. Би юу хэлэх гэж байна гэхээр Бямбацогт дарга бас энийг нарийн үзэхгүй бол энэ цэцийн шийдвэрийн цаана улс төрийн намын бүртгэл ч гэсэн Улсын дээд шүүх хийх боломжгүй гэдэг агуулга харагдаж байгаа шүү. Яг ижил зарчим. Хуулийн этгээдийн бүртгэл талаасаа. Тэгээд ер нь Сонгуулийн ерөнхий хорооны эрх зүйн байдал, чиг үүргийг ойлгомжтой болгомоор байна. Сонгууль зохион байгуулдаг гэдэг боловч сонгуулийг бараг зохион байгуулалтын бүх хар бор ажлыг нь Улсын Бүртгэлийн ерөнхий газар хийдэг. Энэ улс төрийн намын бүртгэлд ч гэсэн цаашдаа Сонгуулийн ерөнхий хороо нь бүртгээд явах уу, үгүй юу. Тэр Сонгуулийн ерөнхий хорооны гарсан шийдвэрийг нь Үндсэн хуулийн цэц юм уу, тодорхой шатны захиргааны бөгөөд Улсын дээд шүүх нь хянадаг, нягталдаг байх нь зөв байх. Ингэж байж бас иргэдийн Үндсэн хуулиар хамгаалагдсан шударга шүүхээр эрхээ хамгаалах байдаг юм уу, энэ зөрчигдсөн эрхээ сэргээлгэх энэ бололцоо бүрдэнэ. Энийг бид хэд ер нь цаашдаа анхаарахгүй бол яах вэ зүгээр Улсын дээд .../минут дуусав/

**С.Бямбацогт:** Асуултаа гүйцээгээд асуучихъя. Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

**П.Сайнзориг:** Яг одоо яах вэ, зүгээр займчиж байна л даа. Улс төрийн намын бүртгэл бол чухал гэдэг байдлаар Улсын дээд шүүх хүсэлтээ гаргасан байна. Тэгэхдээ улс төрийн нам байна уу, мэргэжлийн холбоо байна уу ялгаагүй хуулийн этгээд, энэ этгээдийн бүртгэл, түүнийг дагасан өөрчлөлт болон татан буулгахтай холбоотой харилцааг явж болохгүй юм гэдэг л зарчмыг үндсэндээ өнөөдөр Үндсэн хуулийн цэцээс тогтоож өгч байна шүү. Тэгэхээр бид нар энэ дээр яаралтай ажлын хэсэг гаргаад, цаашдаа ер нь энийг яах вэ гэдэг зүйлээ бодохгүй бол болохгүй нь гэдэг зүйлийг би энэ Цэцийн шийдвэрийн цаад талын үр дагаврыг харж байгаа учраас хэлж байгаа юм. Тэгээд энийг бас Улсын Их Хурлын дарга анхааралдаа аваад, бас дүгнэлт хийгээд, ажлын хэсэг гаргах уу, яах уу та бас анхааралдаа аваач ээ гэж хүсэж байна.

**С.Бямбацогт:** Ойлголоо. Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээс сая Сайнзориг гишүүний ярьж байгаа асуудал дээр тодорхой лавлагаа танилцуулга шийдэл бэлдэж өгөөрэй. Ямар шийдэл байж болох уу. Итгэмжлэгдсэн төлөөлөгч Отгоншарын Батнайрамдал гишүүн хариулъя.

**О.Батнайрамдал:** Сайнзориг гишүүний бас сая нэмэлтээр хэлсэн тайлбарын хүрээнд бас нэмэлт энэ дээр жишээ хэлье. Яах вэ Үндсэн хуулийн цэцийн тайлбар

дээрээ бас ийм хөндлөнгийн шинжээч аваад, олон улсын жишгийг бас харсан байгаа юм. Дэлхийн жишгээс мэргэжлийн нэгдсэн холбоодын асуудлыг болохоороо илүү захиргааны байгууллага, тэр дундаа салбарын яам, Хууль зүйн товчоо, Иргэний хэргийн яамны эрхлэх чиг үүрэгт бол багтдаг юм байна. Цөөн тохиолдолд ердийн холбооны бүртгэл шүүх эрх мэдлийн байгууллагад харьяалагддаг боловч бүртгэл нь илүү анхан, давж заалдах шатын шүүхэд байдаг бол Улсын дээд шүүх дээр харьяалуулсан нь ингээд бусад орны загвараас ингээд ялгарч байна гэж гарсан байгаа юм. Тэгэхээр магадгүй яг энэ дэлхийн жишиг дээр бас улс төрийн намын бүртгэл яг хэр байдаг юм. Үнэхээр Улсын дээд шүүх дээрээ харьяалагддаг юм уу гэдгийг бас энэ дээр бас давхар харах нь бас .../минут дуусав/

**С.Бямбацогт:** Гишүүд танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. 2 гишүүн асуулт асууж, үг хэлсний дараа санал хураалт явагдана. Өнөөдрийн санал хураалт энэ асуудлаар дуусаж байгаа. Тийм болохоор гишүүд танхимдаа хүрэлцэн ирж, санал хураалтдаа оролцоно уу. Болдын Уянга гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Уянга:** Энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр болохоороо бүгдээрээ мэргэжлийн нэгдсэн холбоодыг хэн бүртгэх вэ гэдэг асуудлаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг тэгээд Хууль зүйн байнгын хороогоор хүлээж авсан асуудлыг хэлэлцэж байна. 2024 онд Улсын Их Хурал шинэчлэн зохион байгуулагдсанаас хойш Улсын Их Хурал дээр нийт ийм 17 цэцийн дүгнэлт орж ирсэн байгаа юм. Нэлээн олон орж ирсэн гэсэн үг. Тэгэхээр ер нь Улсын Их Хурлаас өмнө нь батлагдсан хууль тогтоомжууд ямар нэгэн байдлаар л Үндсэн хууль зөрчсөн байх нь тогтоогдоод байна гэсэн үг. Тэгээд энэ дээр хариуцлагын шинж чанартай асуултыг асуух гэсэн юм. Энийг манай Их Хурлаас итгэмжилсэн төлөөлөгч Батнайрамдал гишүүн маань хариулахаар байна уу. Уг нь бол Цэцийнхэн өөрсдөө хариулах ёстой юм шиг.

Тэгэхээр анх энэ хууль Улсын Их Хуралд өргөн баригдахад Дээд шүүх бүртгэнэ гэсэн зохицуулалт орж ирээгүй байгаа юм. Орж ирээгүй. Тэгээд Засгийн газрын 2018 оны 7 сарын 9-ний өдрийн 30 дугаар хуралдааны тэмдэглэлийг харахаар төрийн захиргааны төв байгууллага нь бүртгэнэ гэсэн агуулгатай орж ирсэн байгаа юм л даа. Тэгтэл Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэгдэх үедээ энэ яам зөвшөөрөл өгөхийг нь Зөвшөөрлийн тухай хуульд байхгүй учраас ерөөсөө Дээд шүүх болгочихъё гээд ажлын хэсэгт байсан гишүүд гар өргөөд шийдчихсэн. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн зөрчилтэй заалтыг оруулсан субъект өөрөө хариуцлага хүлээх үү. Энэ 2018, 2019 он, тэрнээс хойш хэдэн жил явчхаад, хэчнээн байгууллага хохирчхоод байхад энэ хариуцлага хүлээх субъект нь хэн байх вэ. Зүгээр л хуулиасаа энэ заалт нь хүчингүй болчихоор ингээд болчих уу. Уг нь бол Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22.2-т яах вэ, нөхөн төлбөр, хохирол байвал яаж барагдуулах вэ. Энийг шийдвэрлэ гэсэн заалт бол байна. Энэ хэрэгждэг юм болов уу.

Өчигдөр Улсын Их Хурлын чуулганаар Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүйтэй холбоотой асуудал, тэр хууль хэлэлцэгдэх эсэх нь дэмжигдлээ. Энэ хуулийг бол эсэргүүцээд байгаа гишүүдийн гол асуудал нь Үндсэн хуулийн цэц аливаа албан хаагчийг, албан тушаалтныг эгүүлэн татах асуудлыг шийдвэрлэх субъект биш байтал ийм эрх энэ хууль хэрвээ батлагдвал олгогдох гэж байгаа. Тэгэхээр хэдэн жилийн дараа хэн нэгэн нь Үндсэн хуулийн цэц дээр гомдол гаргах юм байна л даа. Тэгэхээр нь Цэцийнхэн авч үзээд, Үндсэн хууль зөрчихсөн байна шүү дээ гэхчэнгүүт тэр хүртэл эгүүлэн татагдсан Улсын Их Хурлын гишүүд тэр агуулгыг

оруулж ирсэн субъект ямар нэгэн хариуцлагад оногдох болов уу. Энэ дээр хариулт авъя.

**С.Бямбацогт:** Отгоншарын Батнайрамдал гишүүн асуултад хариулъя.

**О.Батнайрамдал:** Уянгаа гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлаас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн сэдэв болон эрх үүргийн хүрээнд хариулъя. Та хэлж байх шиг байна. 17 Цэцийн дүгнэлт Улсын Их Хурал дээр 2024 оноос хойш ирсэн байна гээд. Энэ өнөөдрийн бидний хэлэлцэж байгаа Цэцийн дүгнэлт гарсан бас үндэслэл нь Монгол Улсын иргэн Номин, Баясгалангийн гаргасан мэдээлэл, Улсын дээд шүүхийн хүсэлтээр энэ хууль зөрчсөн эсэхийг тогтоолгохоор гомдлын хүрээнд бол Цэцийн дунд суудлын дүгнэлт гараад, Улсын Их Хурал дээр хүргэгдсэн байгаа. Та өөрөө бас нэлээн судалсан байна л даа. Анх миний харснаар бол анх Засгийн газраас өргөн барьсан хуулийн төсөл дээр Улсын дээд шүүх бүртгэнэ гэсэн агуулга байгаагүй гэж ойлгосон. Дараа нь Улсын Их Хурлын Байнгын хорооны хэлэлцэх хүрээнд ажлын хэсгийн хүрээнд бол Улсын дээд шүүх дээр бүртгэх нь зүйтэй гэсэн саналын томъёолол орж батлагдсан гэж ойлгосон байгаа. Хариуцлага хүлээх субъектийн хувьд өнөөдрийн яг дүгнэлтийн хүрээнд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүргийн хүрээнээс гарчихсан асуулт учраас энийг орхиод явъя гэж бодож байна.

Тэгээд ёс зүйн асуудал, ер нь Үндсэн хуулийн цэц дээр өнөөдөр улс төрийн намын бүртгэл явдаг юм байна. Мэргэжлийн нэгдсэн холбоодоор бас мэргэжлийн нэгдсэн холбоод буюу төрийн бус байгууллагын бүртгэл явахаар ингэж болсон юм байна. Сая бас орж ирсэн хуулиар бас нэг ёсондоо дээд шүүх дээр Үндсэн хуулийн цэц дээр бас нэмэлт агуулгууд орж ирж байна л даа. Тэгэхээр энийг бас цаашдаа Улсын Их Хурлын хүрээнд ч бас ярилцах нь зүйтэй л гэж бодож байна.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын мэргэжлийн Байнгын хороод энэ цэцийн дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороо, нөгөөдөх нь аль Байнгын хороо билээ. Эдийн засгийн байнгын хороо бас хэлэлцсэн байгаа. Тийм болохоор энэ хэлэлцэж байгаа энэ асуудал, Байнгын хорооныхоо санал, дүгнэлтээ оруулж ирсэн асуудал дээр анхаарах ёстой шүү. Энэ дээр Байнгын хорооны дарга нар, Байнгын хороодын ажлын алба, тэгээд итгэмжлэн төлөөлөгчид бүх юмыг ацаглагчаад ингээд өөрсдөө алга болчихдог байж таарахгүй. Энэ гишүүдийн яриад байгаа асуудал дээр онцгой анхаарч, ямар шийдэл байх талаар танилцуулаарай. Болдын Уянгаа гишүүн.

**Б.Уянгаа:** Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиар үйл ажиллагаагаа явуулж байгаа байгууллага байгаа юм. Тэгээд ингээд Их Хурлаас хууль батлуулчихдаг. Тэгээд хэдэн жилийн дараа зөндөө олон иргэн, аж ахуйн нэгж хохирсны дараа аль нэг заалтыг нь ингээд хүчингүй болгоод л сууж байдаг ийм байгууллага болчихоод байгаа юм байна. Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийн тухай хууль дээр магадгүй өөрчлөлт оруулах ёстой байж магадгүй. Тэгээд их олон арван мундаг хуульчид бол Улсын Их Хуралд байхгүй, тэгэхдээ ажиллаж байна. Тэгэхээр тэр хуульчдаа бас уримаар байна. Хичээнгүйлэн хүсмээр байна. Одоо энэ олон агуулгууд шинээр нэмэгдэх гээд байна. Үндсэн хуулиар олгогдсон эрхээс нь давсан асуудлыг хуульчилж гаргах гээд байна. Энэ дээр саналаа нээлттэй илэрхийлээч ээ. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль дээр хамтарч ажиллахыг хүсье.

**С.Бямбацогт:** Үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна. Гишүүд үүний дараа санал хураалттай. Чуулганы танхимд хүрэлцэн ирэхийг урьж байна. Санал хураалттай шүү. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

**С.Эрдэнэбат:** Энэ бүртгэлийн асуудал цэц дээр, ер нь шүүх дээр ч гэсэн манай нэгдэн орсон конвенц, мөн Монгол Улсын хууль 2 хоорондоо зөрчилдвөл нэгдэн орсон конвенцыг дагаж мөрдөнө гэдэг ийм хууль байдаг. Олон улсын жишиг нь ч гэсэн тийм. Тэгэхээр олон улсад яадаг вэ гэхээр эвлэлдэн нэгдэх эрхийг хэн нэгэн захиргааны этгээд бүртгэх, бүртгэхгүй гэдэг асуудлыг бол хязгаарладаг тодорхой хэмжээнд нь. Энэ талаас нь болох юм бол Дээд шүүх. Дээд шүүх бүртгэхгүй гэх юм бол улсын бүртгэлд бүртгэнэ гэдэг чинь энэ чинь төрийн захиргааны байгууллага шүү дээ. Тэгэхээр энэ чинь өөрөө хууль, эрх зүйн хувьд нь ер нь углуургаараа ер нь манай энэ төрийн бус байгууллагуудыг бүртгэх, зөвшөөрөл олгох гээд ийм асуудлууд маань зарим талаараа бол тээг саад болох гээд байдаг. Олон улсын конвенцууд болон хүний эрхийн пактуудтай зөрчилдөөд байдаг. Тэгэхээрээ Дээд шүүх бүртгэхгүйгээр Улсын бүртгэлд бүртгэсэн тохиолдолд яг тэр 2 байгууллага нь адилхан төрийн институц байгууллагууд. Яг ямар ялгаа гарах вэ гэдэг тал дээр нь юу гэж үндэслэсэн юм бол гэдгийг нь тодруулж асуумаар байна.

2 дугаарт мэргэжлийн холбоод гээд энэ холбоодын юутай нэлээн хариуцлагатай хандахгүй бол би өмнөх гишүүдтэй бол санал нэг байна. Манай зарим мэргэжлийн холбоод дээр насаараа байчихсан, яг өөрийнх нь хувийн өмч юм шиг, хурал зөвлөгөөнөө хийдэггүй, хамаатан садан бизнесийн бүлэглэл гэдэг юм уу, юу гэдэг юм түүгээрээ ингэчихсэн ийм хүмүүс байна. Одоо яах гэж байна вэ гэхээр энэ хүмүүс чинь олон хуулиуд дээр төрийн эрхүүдийг тийшээ өгье л гээд байгаа. Тэр төрийн эрхийг авах гэж байгаа хүмүүст бид нар хэнд, юу хадгалуулах гэж байна вэ гэдэг дээрээ маш сайн үнэлэлт, дүгнэлт өгөхгүй бол энэ чинь аюул болно шүү. Маш олон хүний эрх ашигтай холбоотой асуудлууд гарч ирнэ.

Тийм учраас энэ институцлэгдсэн байгууллагууд ямар байгууллагуудад энэ төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх вэ гэдэг энэ зүйлүүд дээрээ хуулиа ер нь нийтэд нь авч үзэхгүй бол болохгүй. Тухайлбал Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим ч гэдэг юм уу, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо ч гэдэг юм уу ийм олон жил болчихсон, олон мянган гишүүдийг төлөөлдөг дотроо хяналтын байгууллагуудтай, 3, 4 мянган давхар дотроо мэргэжлийн холбоод нь ингээд байж байдаг зүйлүүдийг задлаад, дуртай хэсэг нь ийм холбоод байгуулаад, тэгээд төрийн чиг үүргийг авна гэдэг байдлаар. Магадгүй зарим манай сайд, дарга нар төрийн өндөр албан тушаалтнууд ч гэсэн хувь хувьдаа нэг ийм төрийн бус байгууллагуудтай. Тэгээд тэрүүндээ 1 талаасаа эрх шилжүүлээд, нөгөө талдаа өөрөө тосоод авдаг ийм зөрчлүүд байгаа юм биш байгаа. Тийм учраас энэ дээр бол бид нар нэлээн нухацтай авч үзэхгүй бол болохгүй. Яах вэ ер нь бол Дээд шүүх ингээд бүртгэх гэдгийг бол хүлээж авах нь зөв. Гэхдээ үүний дараа ингээд хаячхаж болохгүй. Улсын бүртгэл нь хаяна гэдгийг дахиад хууль дээрээ бид бүхэн өөрчилж, дахиж авч үзэх ийм асуудал яригдав уу, үгүй юу Цэц дээр. Тэрийг тодруулж асуумаар байна.

**С.Бямбацогт:** Отгоншарын Батнайрамдал гишүүн хариулъя. Хууль зүйн байнгын хорооны дарга, Эдийн засгийн байнгын хорооны дарга бас Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асууж байгаа. Тийм болохоор хариулах ёстой шүү. Зөвхөн итгэмжилсэн төлөөлөгч бүх юмыг хариулна биш. Мэргэжлийн

Байнгын хороод өөрсдийн байр суурь, санал, дүгнэлтээ бас илэрхийлж байх ёстой. Батнайрамдал гишүүн.

**О.Батнайрамдал:** Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн энэ яригдаж байгаа асуудал бол Мэргэжлийн нэгдсэн холбоо гэсэн төрийн бус байгууллагыг хууль зүйн хүрээнд бүртгэх асуудлыг л ярьж байгаа юм. Тэгэхээр энэ бүртгэх чиг үүрэг нь гүйцэтгэх засаглалын тэр төрийн захиргааны төв байгууллага эсвэл төрийн захиргааны байгууллага дээр байх уу эсвэл үндсэн мэргэжлийн нэгдсэн холбоодын тухай хууль дээр заасанчлан Улсын дээд шүүх хяналтын шатын шүүхийн үндсэн чиг үүрэг дотор байх уу гэдэг асуудал л яригдаж байгаа юм л даа.

Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд бол бас ингэж хэлсэн байгаа юм. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар Мэргэжлийн нэгдсэн холбоо гэх төрийн бус байгууллага үүсгэн байгуулагдсаныг Улсын дээд шүүх дээр бүртгэхээр заасан нь шүүхийн үндсэн чиг үүрэг, мөн чанар, тэр дундаа Улсын дээд шүүх хяналтын шатын шүүхийн үндсэн чиг үүргийн агуулгад харшлахуйц байна. Нөгөө талаар гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүргийн асуудлыг шүүх эрх мэдлийн байгууллагад хариуцуулсан нь Үндсэн хуулийн эрх мэдлийн хуваарилалтын зарчимтай бас зөрчилдөж байна. Мөн эрх зүйн онол хууль зүйн чиг үүргийн хүрээнд бол шүүх эрх мэдлийн чиг үүрэгтэй зөрчилдөх үр дагавар үүсгэхээр байна гэж заасан байгаа юм. Тэгэхээр бид нар өнөөдрийн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж аваад, хэрвээ хүлээж авах юм бол ажлын хэсэг хамаарах Эдийн засгийн байнгын хороо дээр яаралтай байгуулж, энийг яг таны хэлсэнчлэн энэ бүртгэлийг улсын бүртгэл дээр юм уу эсвэл танхим дээр юм уу энийг бид нар нэг ёсондоо шийднэ гэсэн үг. Гэхдээ энийгээ бол ажлын хэсэг байгуулаад, дахиад Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт маягаар хуулийн хугацаанд нь багтааж оруулж өөрчлөх шаардлагатай юм байна лээ.

**С.Бямбацогт:** Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

**С.Эрдэнэбат:** Яг энэ утгаар нь авч үзвэл түрүүний Сайнзориг гишүүний хэлдэг шиг намуудыг бүртгэж байгаа нь яг адилхан Үндсэн хуулийн зөрчил рүү орох нь байна шүү дээ. Тэгэхээр энийг бол нэлээн сайн бид бүхэн бас нухацтай авч үзмээр л болох юм байна даа гэдгийг би хэлмээр байна. Нөгөө талд нь Улсын бүртгэлийн газрыг өөрсдийг нь яг энэ дүрэм болон тухайн мэргэжлийн холбоод юунууд дээр хянадаг, хуульд нийцэж байгаа эсэхийг нь хянадаг тийм чадавх гэдэг юм уу субъект юмыг нь бий болгож өгөхгүй бол яг өнөөдрийн байдлаараа авч үзээд тэр дүрмийг нь хянаж үзээд тавьдгаар явах юм бол яг тийм чадавх бүтэц бол байхгүй. Тийм учраас энийг би бол давхар Бүртгэлийн тухай хууль болон бусад энэ бүртгэлтэй холбоотой төрийн бус байгууллагуудыг нам, шашин, үйлдвэрчний эвлэл, танхим, мэргэжлийн холбоодыг бүртгэх асуудлыг ер нь цогцоор нь л авч үзэхгүй бол болохгүй юм байна. Тэгэхгүй бол мэргэжлийн холбоодыг нь ингэнэ. Нам бол болно. Эсвэл танхим болно, болохгүй гэдэг ийм 2 юу байж болохгүй.

**С.Бямбацогт:** Санал хэллээ. Санал хураалттай шүү. Гишүүдийг танхимд урьж байна. Гишүүд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулж Байнгын хороодын хэлэлцсэн санал, дүгнэлтээс асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо Байнгын хороодын бэлдсэн саналаар санал хураалт явуулна. Гишүүдийг танхимд урьж байна. Өнөөдөр чуулганы ирцэд 94 гишүүн буюу 74,6 хувийн ирцтэй байгаа.

Энэ суудлууд дээр саналаа хураагаад, санал хураалтыг бас харьцангуй гишүүдэд бас төвөг багатай, хүндрэл багатайгаар бас цагийг нь зохицуулж байгаа. Өнгөрсөн 7 хоногт бас тэгж зохицуулсан. Энэ 7 хоногт бас ингэж зохицуулсан. Санал хураалтыг хийчихвэл өөр санал хураалт өнөөдөр байхгүй. Хуулийн хугацаатай. Чуулганы танхимд байгаа гишүүдээ зарлаж сурталчлах уу. Ажлаа сайн хийдэг гэж. Тэгэхээр байхгүй нь бол байхгүй гээд ойлгогдох байлгүй. Чуулганы хуралдаандаа идэвхтэй оролцож байгаа гишүүдээ бас зарлаж болно. Гишүүд маань орж ирж байна. Тэгээд өнөөдөр энэ санал хураалтуудаар санал хураагаад үндсэндээ санал хураалт дуусна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо Байнгын хороодын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад 53 гишүүн бэлэн болсон байна. Бэлэн бус 42 гишүүн байна. Санал хураалтдаа бэлтгэж амжаагүй болон танхимд хүрэлцэн ирж амжаагүй гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирж, санал хураалтад оролцохыг хүсье.

Ирцийн санал хураалт. Цаашдаа ер нь бас чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд бас энэ санал хураалтаа ирцтэй болгож бүртгэдэг байх зохицуулалт бас орох ёстой гэж ойлгож бодож байгаа. Төлөвлөж байгаа. Ирцийн санал хураалт. Санал хураалтад 55 гишүүн орсон байна. Санал хураалтын бүртгэлд ороогүй гишүүд танхимдаа ирэхийг урьж байна. Нэр нь тэр самбар дээр гүйж байгааг харж байгаа байх. Энэ гишүүд санал хураалтдаа ирж оролцохыг урьж байна. Санал хураалтаа явуулъя.

1.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 ,7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “ .... шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх .... эрхтэй.” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 56 гишүүн буюу 59.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Наранбаяр гишүүн, Ганзориг гишүүд дэмжсэнээр авъя.

Дараагийн санал хураалт.

2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 ,7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 94

гишүүн санал хураалтад оролцсоноос 59 гишүүн буюу 62,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Туваан, Эрдэнэболд, Батбаяр нарын урилгаар Төв аймгийн Эрдэнэсант сумын ерөнхий боловсролын сургуулийн 12<sup>Б</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт хүүхэд багачууддаа Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилтыг хүсье. Амьдралд нь эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Санал хураалтын дүнг танилцуулсан байгаа.

3.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 94 гишүүн санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 60,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 8.7 дахь хэсэгт “... Улсын дээд шүүх...”, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “... Улсын дээд шүүхийн Тамгын газар...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавь дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 58,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Байнгын хороодын саналаар санал хурааж дууслаа.

Байнгын хороодын саналыг санал хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо.

Санал хураалтад оролцсон Улсын Их Хурлын гишүүддээ талархал илэрхийлж байна. Санал хураалтад оролцоогүй гишүүд бас дараагийн чуулгандаа ирж оролцож байхыг хүсье.

11.31 цаг.

Дараагийн асуудалд оръё.

**Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх төрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүдээс 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны 2026 оны 4 дүгээр сарын 9, 10-ны өдрүүдийн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан.

Тус Байнгын хороо нэгдсэн хуралдаанаа хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төслийн холбогдох зүйлд тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд олонхын дэмжлэг авсан саналыг нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Ирцийн дарааллаар орсон уу. Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууна уу.

**Д.Энхтүвшин:** Энэ хуулийн аймаг, нийслэл гэдэгтэй бол санал нийлэхгүй байгаа юм. Давхар дээлтэй. Одоо бид нар энэ иргэдээ төлөөлж чадахгүй төлөөлөгч нартай болчихсоны жишээг нийслэл дээр зөндөө харж байна шүү дээ. Дахиад улам энэ дархлааг байхгүй болгож байгаа ийм хуулийн төсөл оруулж ирж байгаа. Тэгээд энэ төлөөллийн байгууллага нь гүйцэтгэх байгууллагатайгаа холилчихсон, тал нь холилдьё гэдгийг зөвшөөрье гэдэг хууль оруулж ирж байна. Нийслэлд хүн олдохгүй байна гэж байхгүй шүү дээ. Иргэдийн төлөөлөгч нь төлөөлөгч шиг байх ёстой. Иргэдийнхээ дуу хоолойг илэрхийлдэг байх ёстой. Гүйцэтгэх байгууллагадаа

шаардлагыг нь тавих ёстой байтал өөрсдөө ингээд дандаа тэр төлөөллийн байгууллагууд нь шагнал урамшууллын маягтай юм уу, бараг ихэнх нь Жишээлбэл нийслэл дээр Нийслэлийн өмчит компаниудын ТУЗ-ийн дарга, төслийн менежер, Засаг даргын орлогч, зөвлөх гэх мэтчилнээр бүгдээрээ ингээд иргэдийг төлөөлөх бие даасан байдлаа хадгалж чадахгүй болчихсон байгаа шүү дээ. Тэгээд энийг хуулиар баталгаажуулах гэж байгаа ийм хуулийн төсөл орж ирж байгаа. Тэгээд энийг бол нийслэлтэй холбоотой эсэхийг нь бол ерөөсөө дэмжихгүй байгаа. Яг энэ ижил агуулгатай хууль 2018 онд Ж.Мөнхбат гишүүн бас өргөн барьж байсан юм байна лээ. Тэгээд тэр үед ч гэсэн бас яг Засгийн газар ч гэсэн тодорхой саналууд хэлж байсан. Энэ хяналт байхгүй болох нь ээ. Иргэдийн хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх энэ боломж нөхцөлийг хязгаарлах ийм эрсдэлтэй байна гээд асуудлууд бас ярьж байсан. Тэгэхээр энэ асуудал дахиад орж ирж байна. Тэгээд асуулт нь одоо нийслэл дээр НИТХ-ын хэдэн гишүүн нь гүйцэтгэх байгууллагад нь ажиллаж байгаа вэ. Энэ талаар мэдээлэл өгөөч.

Тэгээд энэ хууль маань одоо бид нар жишээлбэл Засгийн газар дээр чинь энэ давхар дээлтэй холбоотой асуудлууд дээр зовлонг нь амсаж байгаа шүү дээ. Улсын Их Хурлын 126 гишүүнээс өөр сайд хийх хүн Монголд байхгүй юм шиг байдалтай бүгдийг нь давхар дээлтэй болгочихсон. Одоо яг энэ болохгүй, бүтэхгүй байгаа юмаа нийслэл дээр үргэлжлүүлж байна. Сум, сумын түвшинд бол ойлгож байсан. 30 хувийн давхар дээлтэй байх боломжийг нь хуулиар олгочихсон байсныг нийслэл дээр 50 хувь болгож өргөтгөж байгааг бол энэ яг хяналт тэнцлийн зарчим, иргэдийг төлөөлөх энэ байдлыг алдагдуулах гэж байгаа ийм хууль байгаа. Тэгээд одоогийн нийслэлийн нөхцөл байдал нь ямаршуу байдалтай байгаа юм. Сошиалаар зөндөө л явж байна шүү дээ. Бараг ихэнх нь гүйцэтгэх байгууллагадаа орчихсон. Нийслэлийн иргэдийг төлөөлөх ямар ч чадвар чадамж, боломжгүй болчихсон. Тэгээд энэ талаар мэдээлэл өгөөч.

**С.Бямбацогт:** Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асууж байгаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга болон ажлын хэсгийн ахлагч, хэрвээ байхгүй бол санал, дүгнэлт уншсан гишүүн асуултад хариулах дэгтэй. Ингээд Баярмагнай Баярбаатар гишүүн асуултад хариулъя.

**Б.Баярбаатар:** Баярлалаа. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Зүгээр таны хэлсэн эхний саналтай зарим нэг зүйлээр бол онолын түвшинд бас нийцэж байгаа. Өнөөдөр энэ өргөн барьсан хуулийн төсөл дээр анх бол аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн 50 хувь гэж орж ирсэн юм. Тэгээд энэ нь зарчмын зөрүүтэй санал гараад 30 хувь болж буурсан байгаа. Нийслэл дээр та статистик тоо асуулаа. Нийслэл 45 төлөөлөгчтэй. Энэ дотроос яг төрийн захиргаа, төрийн тусгай албанд томилогдсон хүн бол байхгүй. Төрийн үйлчилгээний албанд 18, улс төрийн албан тушаалд 17, төрийн өмчит үйлдвэрийн газар, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт бол 10 хүн ингээд томилогдоод ажиллаж байгаа гэсэн ийм тоо баримт байна. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

**Д.Энхтүвшин:** Би нийслэлтэй л холбоотой илүү асуудал яриад байгаа юм. Ер нь бол бие даасан иргэдийг төлөөлөх энэ Үндсэн хуулийн боломжийг саяын байдлаас харахад бол хэрэгжүүлэх боломжгүй харагдаад байгаа байхгүй юу. Талаас илүү нь яг л Нийслэлийн Засаг даргынхаа өөрийн удирдлага дор. Одоо

жишээлбэл, нийслэлийн энэ ажил алба хашиж байгаа хүмүүс бол зүгээр даргынхаа юу гэж хэл гэснийг очиж хэлдэг, хүмүүс рүү дайрдаг иймэрхүү ажлуудыг л хийдэг болчихсон байна лээ шүү дээ. Тэгэхээр ажлын хэсгийн ахлагч болон Байнгын хороон дээр холбогдуулж яг энэ нийслэл бол бие даасан байдлаа иргэдийг төлөөлөх энэ чадвараа хадгалж чадах уу. Талаас илүү нь ийм давхар дээлтэй байна шүү дээ. Ямар нэгэн байдлаар ашиг сонирхлын зөрчилтэй байна. Энийг та хэд хангаж чадна гэж бодож байгаа юу.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг Баярбаатар гишүүн хариулъя.

**Б.Баярбаатар:** Би албан ёсоор бол ажлын хэсгийн дарга бол биш. Байнгын хорооны гишүүний хувьд танилцуулж байгаа. Яах вэ, 50 хувь гэдэг байдлаараа явсан бол бас таны ярьж байгаа зүйл бол хөндөгдөх магадлалтай байсан байх. Өмнө нь 2019 оноос өмнө бол 1/3 гэдэг томьёоллоор зохицуулагдаж байсан. Тэр үед бол аймаг, нийслэлийг нь бол хуулиас аваад, сум, дүүрэг нь бол үлдэж байсан ийм нөхцөл байдал бол байдаг. Одоо ингээд буцаагаад бол 30 хувь гэж төсөл санаачлагч ажлын хэсгийг бол Байнгын хороонд оруулж ирсэн.

2-т гэж хэлэхэд яах вэ, 1/3 гэдэг агуулгаараа захирах, захирагдах ёс, тэр удирдахуйн асуудал дээр бол нөлөөлөл нэг их айхтар нөлөөлөхгүй болов уу гэсэн нөхцөл байдал бол ажиглагдаад байгаа. Байнгын хороо дээр гарсан зарчмын зөрүүтэй санал болон Байнгын хороо дээр яг хэлэлцэгдсэн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх энэ үйл явцтай холбоотой асуултад бол би хариулна. Яг төсөл санаачлагчийн үзэл баримтлал, судалгаанд суурилсан .../минут дуусав/

**С.Бямбацогт:** Санаачлагч хариулах дэг байхгүй. Ер нь бол хуулийг хэлэлцэх эсэх асуудал дээр санаачлагч хариулдаг. Анхны хэлэлцүүлгээс хойш бол Байнгын хороо, ажлын хэсэг хариулах ийм дэгтэй гэдгийг гишүүддээ бас сануулъя.

Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагайн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 12<sup>Б</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ сурлагын өндөр амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе. Онц сураарай бүгдээрээ. Хүссэн сургуульдаа ороорой. Хүссэн мэргэжлээ эзэмшээрэй.

Жамбалын Ганбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууя.

**М.Нарантуяа-Нара:** Өдрийн мэнд. Энэ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид төрийн албан хаагч байна гэдэг чинь яг энэ Улсын Их Хурлын гишүүд нь Засгийн газарт давхар дээл өмсөж байгаатай ялгаагүй юм болчхож байгаа байхгүй юу. Тэгээд Засгийнхаа талд ажиллах юм уу, Их Хурлынхаа талд ажиллах юм уу. Иргэдээ төлөөлж ажиллах юм уу, эсвэл Засгийн газрынхаа байр суурийг хамгаалж ажиллах юм уу гэдэг ийм юм болдог шүү дээ яг үнэндээ. Яг тэр шиг юм болох гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол бас одоо яах вэ, боловсон хүчин, хүний нөөц, мэдлэг ур чадвар гээд байна. Тэгвэл тэр дээр чинь өөрөө мэдлэг, ур чадвар хэмжих юу байдаг юм уу. Угаасаа иргэдийг л төлөөлж байвал тэнд чинь хэн ч гарч ирж, Их Хуралд хүртэл хэн ч гарч ирж болж байгаа биз дээ. Иргэдийг төлөөлж

чадна гээд иргэдээс санал авч гарч ирвэл энэ хүн ажиллаж болдог шиг, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ч гэсэн тийм байвал яасан юм бэ гэдэг асуудал байна.

Тэгээд бас энэ ёс зүйн асуудлыг ярихад манай Их Хурал чинь их сонин юм байна. Би чинь цөөнхийн ард түмний төлөөллөөр ингээд гараад ирчихсэн Улсын Их Хурлын гишүүн гээд өөрийгөө бодож байгаа. Бүгдээрээ ийм байдлаар гарч ирдэг гэж бодсон чинь манай Улсын Их Хуралд чинь ээж, хүүхдүүд хүртэл байж байдаг юм байна шүү дээ. Манай Батшугар гишүүн чинь хойд ээжтэйгээ байдаг юм байна. Энэ Намбарын Энхбаяр гэдэг хүний гэр бүлийн хүн нь болчихсон гээд ингээд яригдаад байна.

**С.Бямбацогт:** Гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж үг хэлнэ.

**М.Нарантуяа-Нара:** Байж байгаарай. Би ярьж байна. Энэ ингээд яваандаа холбогдоно дарга аа, хүлээж байгаарай та. Тэгээд энэ Ёс зүйн дэд хорооны дарга Хэрлэн гишүүнийг та бол Их Хурлын даргын хувьд ёс зүйн манлайлал үзүүлээд, ард түмний татвар төлөгчдийн мөнгөөр сурсан 250 сая төгрөгөө төлчхөөд, та энэ ёс зүйн хороог ахалж ажилла гэдэг энэ шаардлагыг та тавих ёстой байхгүй юу. Гэтэл тавихгүй байна шүү дээ. Дээрээс нь өнөөдөр би уг нь Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай би танд бичгээр бас саналаа өгсөн байгаа. Тэгээд энэ Дэгийн тухай хууль чинь өөрөө бас энэ Улсын Их Хурлыг нийгэм, цаг үе, эдийн засаг, нөхцөл байдал, иргэдийн яг энэ орчин нөхцөлд болж байгаа цаг үеийн асуудлаар дуу хоолойгоо илэрхийлэхэд бүрэн хязгаарлалт болчихсон ийм хуулийн асуудлыг бас бид нар засаж янзалмаар байна. Тэгээд ингээд ёс зүйн асуудал ярихаар бүгдээрээ над руу дайраад байдаг. Гэтэл энэ иргэдээ төлөөлж байгаа хүмүүс чинь өөрсдөө энэ дотор бас ёс зүйтэй байж чадаж байна уу гэдэг асуудлыг бас яримаар байна шүү дээ.

Дээрээс нь Улсын Их Хуралд Иргэний Зориг Ногоон нам, Иргэний Зориг Ногоон намын дэмжигчдийн, гишүүдийн саналаар энд орж ирсэн. Гэтэл та өнөөдөр шууд амаараа Иргэний Зориг ногоон нам гэдэг энэ үнэт зүйл, үзэл баримтлалын нэгдэл хамаагүй гишүүд нь дор бүрнээ тоглолт хийж болох ийм юмыг бас та ярьж байна. Жишээлбэл, Байнгын хорооны одоо бид нар саналаа танд хүргүүлсэн. 3 гишүүний ингээд зөвлөл хуралдаад, ийм саналаа хүргүүлж байхад та тэрийг уншаагүй. Уншаагүйгээр үл барам та энэ Их Хуралд манай намын 1 хүнийг улайм цайм ингээд байр суурийг нь хадгалж, хамгаалж байгаа байдал чинь та өөрөө энэ Их Хурлыг даргалах ямар ч боломжгүй нөхцөл байдлыг илтгээд байна. Монгол Ардын нам 30, 38-аар хуваагдчихсан байгаа энэ цаг үед энэ Их Хурлын чинь олонх нь Ардчилсан нам болчихоод байгаа юм биш үү. 46-аараа. Тэгэхээр Ардчилсан намаас энэ Улсын Их Хурлын даргыг томилохгүй бол энэ өөрөө Монгол Ардын намын Их Хурал шиг харагдаад байна шүү дээ. Харагдах ч биш бүүр яг тийм хүчин зүйл үйлчлээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ зүй ёсны зарчмын асуудлыг бас үнэхээр Улсын Их Хурлын хүрээнд авч хэлэлцэхгүй бол болохгүй байна. Төрийн 3 өндөрлөг гурвуулаа Монгол Ардын нам. Тэгээд ерөөсөө тэр чигтээ Монгол Ардын намын зохион байгуулж байгаа эрх ашигт нийцсэн ийм үйл ажиллагааг хүчиндээд явуулаад байна шүү дээ. Тэгэхээр энд Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрх гэдэг юм .../минут дуусав/

**С.Бямбацогт:** Надтай холбоотой асуудал ярьсан учраас би бас тайлбар өгчихье. Нарантуяа-Нара гишүүн ээ. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд та өөрчлөх санал ирүүлсэн. Үнэхээр бас гишүүдийн үгээ хэлэх, үзэл

бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарласан ийм заалтууд байвал тэрийг хэдүүлээ ярьж байгаад өөрчлөх боломжтой.

2 дугаарт нь Батбаатар гишүүн Улсын Их Хурлын гишүүний бланк дээр намайг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороонд оруулъя. Батболд гишүүнийг энэ байнгын хорооноос гаргая. Нарантуяа-Нара гишүүнийг даргын зөвлөлөөс гаргаж, би оронд нь орно гэсэн бичиг ирүүлсэн. Тэгээд энийг бид нар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн тодорхой заалтыг манай Тамгын газрынхан тайлбарлаад өгчхөөрэй. Улсын Их Хуралд нам, эвслийн бүлэгтэй бол тэр бүлгийн даргадаа бичгээ өгөөд, бүлгийн дарга нь нэгтгээд Их Хурлын даргад хүргүүлэх. Бүлэггүй гишүүд шууд гишүүнийхээ бланк дээр өөрсдөө хүргүүлэх ийм л хуультай юм байна лээ. Яг энэ хуулийн дагуу Батбаатар гишүүний асуудлыг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороонд нь оруулсан. Бусад гишүүдийн бүрэн эрхэд халдаад, гишүүдийн өмнөөс шийдвэр гаргасан, бусад гишүүдийн бүрэн эрхийг хязгаарласан асуудал дээр нь шийдвэр гаргаагүй. Өчигдөр би бас тан руу залгаад, таныг даргын зөвлөлийн гишүүнээс гаргаад, өөрөө орно гэж байгаа чинь зөв юм уу, буруу юм уу гэж асуух гээд бас утасдсан. Та бас утсаа аваагүй ээ. Энийг та бас анхааралдаа аваарай.

Тэгээд Улсын Их Хуралд бол олонх суудалтай намаас л нэр дэвшүүлж бас Улсын Их Хурлын даргыг шийддэг. Олонх суудалтай нам нь Монгол Ардын нам байгаа. Тэгээд хэдүүлээ бас Дэгийн хуулиа бас судлаад, асуудалдаа бас ярьж хөөрч байх нь зөв байх. Одоо тэгээд яг хэлэлцэх асуудалтай холбоогүй асуудлаар бид нар ярилцмааргүй байна. Хэлэлцэх асуудалтай холбоотой хариултыг Төрийн байгуулалтын байнгын хороо, ажлын хэсэг Баярбаатар гишүүн хариулъя.

Тэр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гишүүд үнэхээр ингээд давхар дээлтэй байгаад байгаа нь зөв үү. Энэ дээр чинь та нар өөрчилж болоогүй юм уу гэсэн асуулт асуусан.

**Б.Баярбаатар:** Тэгээд төсөл санаачлагч бол үзэл баримтлалдаа оруулж ирэхдээ ер нь бол Монгол Улс алслагдсан сум суурин, аймаг олонтой. Тэгээд энд өнөөдөр бас иргэдийн төлөөлөл болоод сонгогдсон улс төрийн албан тушаалтнуудын 1/3 нь буюу 30 хувь нь тухайн орон нутагтаа, аймаг, нийслэл, төрийн захиргааны албан хаагчид бол хийж болох юм байгаа юм. Энэ бол яг нэг тийм давхар дээлийн хэмжээнд асуудал гэж ойлгож болохгүй л дээ. Засгийн газрын гишүүн бол улс төрийн албан тушаал, Улсын Их Хурлын гишүүн бол мандат өвөртлөөд сонгогдсон сонгуульт албан тушаал. Тэгэхээр яг аймаг, нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгчид бол иргэдийг хангах эрхээ бол эдэлж, үүргээ бол хүлээж чадаж байгаа гэж бол харж байгаа. Мэдээж 2019 оноос өмнө байсан практик зүйл рүүгээ л одоо бид нар энэ удаадаа бас бодит нөхцөл байдал дээрээ тулаад, эргэж энэ нөхцөл байдал руугаа л орж байгаа ийм байдал байгаа шүү гэдгийг л хэлж байгаа. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Зочин танилцуулчихъя. Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Цагаан нуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 12<sup>Б</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхнийхээ сурлагад нь өндөр амжилтыг хүсье. Амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт

гишүүдийн өмнөөс хүргэе. Тэгээд сайн суралцаад, хүссэн сургуульдаа, хүссэн мэргэжлээрээ элсээрэй гэж ерөөе.

Нарантуяа-Нара гишүүн тодруулж асууя.

**М.Нарантуяа-Нара:** Ялангуяа аймаг, сумын хувьд бол энэ нээрээ бас асуудал болдог асуудал мөн. Ялангуяа сумын хувьд, тосгоны хувьд, багийн хувьд бас яах аргагүй давхардах ийм байдал бас байж болдог юм. Би өөрөө сумд амьдарч байгаа, тосгонд, багт амьдарч байгаа учраас энийг бас мэдрээд байна.

Улсын Их Хурлын дарга аа, та одоо ингээд зөв л дөө зөв. Гэхдээ нөгөө талаар Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг та нэгийг нь илүү хамгаалаад, тэгвэл надад бас Байнгын хороогоо өөрчилмөөр бас хэрэгцээ шаардлага байна. Тэгээд би танд хүсэлт явуулбал та миний хүсэлтийг хүлээж авах юм уу. Одоо өөрөөр хэлбэл Иргэний Зориг ногоон намын хувьд бол бүлэг биш учраас гишүүд нь ганц ганцын хувийн тоглолт хийгээд хувь тоглолтоор явах боломж байгаа юм байна. Тэгэхээр миний хувьд би хүссэн Байнгын хороондоо орох надад боломж, эрх мэдэл байна уу. Байгаа юу.

**С.Бямбацогт:** Хэлэлцэх асуудалтай холбоогүй л асуудал яриад байна. Гэхдээ би танд хариулчихъя. Танд байгаа. Гэхдээ Улсын Их Хурал 126 гишүүдийн суудал юм уу авсан нам, эвсэл, түүний Байнгын хорооны гишүүдэд эзлэх хувь, коэффициентыг харгалзаж хуваарилдаг. Дэгийн тухай хууль та үзээрэй. Тэгээд дэгийн тухай хуульд заагдсан шаардлага хангагдаж байвал танд бүрэн боломжтой. Та өөрийнхөө гишүүний бланк дээр бичиж ирээд. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. Нанзадын Наранбаатар гишүүн асуултаа асууя.

**Н.Наранбаатар:** Нэгжийн хуульд аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч 30 хүртэл хувь нь төрийн албан хаагч байж болно гэдэг энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бол дэмжиж байгаа юм. Миний хувьд бол бас орон нутагт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр 2 удаа бас сонгогдож ажиллаж байсан. Аймгийн иргэдийн Хуралд сууж байсан гэсэн үг. 2008 оноос өмнө 2004-2008 оны хооронд сууж байхад бол төрийн албан хаагчид чөлөөтэй дэвшээд, иргэдийн хуралд суудаг байсан. Тэр үед яадаг байсан бэ гэхээр зэрэг иргэдийн Хуралд мөн иргэдийн Хурлын тэргүүлэгчдэд аймгийн Засаг дарга нь, Тамгын дарга нь, хэлтсийн дарга нар нь ингээд бүгдээрээ ороод суучихдаг байсан юм. Тэгээд өөрөө өөрсдийнхөө ажлыг дүгнээд, өөрөө өөрсдөдөө үүрэг өгөөд л явчихдаг. Дараа нь би 2016-2020 онд аймгийн Иргэдийн Хуралд суусан. Тэгэхэд хуульд өөрчлөлт ороод, төрийн албан хаагчид байхгүй болчихсон байсан. Тэгээд 2 өөр хуулийн орчинд ажиллаж үзсэн л дээ. Тэгэхэд төрийн албан хаагчид байхгүй болчихоор зэрэг иргэдийн Хуралд дандаа бизнесийнх байдаг юм уу, суманд бол малчид, тэгээд л төрийн албанд ажилладаггүй бусад хүмүүсээс сонгогдоод ингээд явчихаар зэрэг бас нэг учир дутагдалтай асуудал гарч ирдэг нь юу вэ гэхээр зэрэг иргэдийн хурлын чадавх тааруу болчихдог. Сумын, аймгийн ажил, амьдрал, төсөв, эдийн засаг, бүх асуудлуудыг хамгийн сайн мэдэж байдаг хүмүүс чинь төрийн албан хаагчид нь байдаг юм. Тэгээд төрийн албан хаагчид нь иргэдийн хуралд орж шийдвэр гаргахад оролцож чаддаггүй. Ингээд хуулиараа хаачихдаг. Ингээд 2 хуулийн өөр орчинд ажиллаж үзсэн.

Үүний хамгийн боломжтой, шийдвэрлэж болохоор хувилбар нь бол энэ холимог. Тэгэхдээ 30 хувь байх нь зүйтэй гэж үзэж байгаа. 50 хувь бол бас тал хувийг нь эзлээд ингээд явчих учраас 30 хувьд нь төрийн албан хаагчдыг оруулаад ингээд явах нь 1 дүгээрт бол тэгш байдлыг бий болгож байгаа юм. Суманд нь зөвшөөрсөн мөртөө аймагт нь хаачихсан байсан бол одоо ингээд тэгш аль нь ч байж болохоор болж байгаа юм.

2-т гэвэл хүний бас сонгох, сонгогдох эрхийг бас хангаж өгч байгаа юм. Төрийн албан хаагч хүн бол бас иргэн. Тийм учраас сонгогдох эрхээ эдлэх ёстой. Дараагийн дугаарт бол төрийн албан хаагч ороод ирснээрээ бас иргэдийн Хурлын чадавх сайжирч, тэрнээс гарч байгаа шийдвэр бас бодитой, тооцоо судалгаатай гарах ийм нөхцөл бүрдэж байгаа гэж ингэж бодож байгаа.

Тэгэхдээ энэ дээр бас 1 зүйлийг хэлье гэж бодсон юм. Хэрвээ төрийн албан хаагчид иргэдийн Хурлын Төлөөлөгч болсон тохиолдолд яг өөрийнхөө хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуудал дээр санал өгдөггүй байх ийм жишиг олон улсад бол байдаг. Яг өөрийнх нь газар, хэлтсийн ажлыг дүгнэх ч байдаг юм уу, тэрэнтэй холбоотой төсөв хөрөнгийн асуудал шийдвэрлэх ийм хурал дээр бол татгалзаад ингээд саналаа өгөхгүй байх ийм зохицуулалт байдаг. Түүнийг бол заавал заавал хуульд хийж өгөхөөсөө илүү тухайн иргэдийн Хурлынхаа хуралдааны дэгтээ оруулаад ингээд явахад бол асуудал байхгүй юм гэсэн ийм дэмжих санал хэлье. Асуулт алга.

**С.Бямбацогт:** Нанзадын Наранбаатар гишүүн санал хэллээ. Одоо Цэндийн Баатархүү гишүүн. Алга байна. Ренчинбямбын Сэддорж гишүүн асуултаа асууя. Алга байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

11.55 цаг.

Дараагийн асуудалдаа орьё.

### **Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль, тогтоолын эцсийн найруулгыг холбогдох Байнгын хороо бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

1.Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

2.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Чуулганы хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

13 цагаас даргын зөвлөлийн хуралтай. Даргын зөвлөлийн гишүүдийг цагтаа ирэхийг урьж байна.

11.56 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*